



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/160

Мандалговь

Сонсох ажиллагаа явуулах ажлын  
хэсэг байгуулах тухай

“Захиргааны ерөнхий хууль”-ийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалт, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төв номын сангийн захирал Ц.Одончимэгтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг захиргааны санаачилгаар цуцлах болсонтой холбогдуулан сонсох ажиллагаа явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч М.Анхбаяр (Аймгийн Засаг даргын орлогч)  
Гишүүд: Б.Түвшинбаяр (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)  
Х.Мөнхсаруул (Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)  
Г.Оюунтунгалаг (Олон нийттэй харилцах ажилтан)

2. Сонсох ажиллагааг 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зохион байгуулж, баримтжуулахыг ажлын хэсгийн ахлагч (М.Анхбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210442